

## **Оросын Холбооны Улс дах санхүүгийн бус тайлагналын ач холбогдол, төлөвшил, хөгжлийн хандлага**

### **The Relevance of Non-financial Reporting, Its Formation and Prospects Development in Russia**

Сорокина Елена Михайловна<sup>1</sup>

#### Хураангуй

Аж ахуйг тогтвортой хөгжлийн бодлогод нийцүүлэн эрхлэхийг өнөөгийн нөхцөл байдал шаардаж байна. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (концепц) XX зууны эцсээр үүсэж бий болсон. Түүнийг хэрэгжүүлэх нөхцлийн салшгүй хэсэг нь бизнесийн мэдээллийн ил тод байдал мөн. Бүхий л сонирхсон хэрэглэгчдийн анхаарлын төвд байдаг нийгмийн хариуцлага, экологи, эдийн засгийн зэрэг компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, үндсэн үзүүлэлтүүд нь санхүүгийн бус тайлагналыг бий болгодог. Өгүүлэлд ОХУ-ын компаниудын санхүүгийн бус тайлагналын талаарх тоо баримтуудыг эш татсан. Мөн санхүүгийн бус тайлагналыг бий болгохтой холбогдсон эрх зүйн болон ОХУ-ын засгийн газраас бизнесийн нийгмийн болон экологийн хариуцлагыг дээшлүүлэх талаар гаргасан хөтөлбөрийн баримт бичгүүдийн агуулгыг авч үзлээ.

*Түлхүүр үес:* тогтвортой хөгжил, Тайлагналын ерөнхий санаачлагын удирдамж (GRI), санхүүгийн бус тайлагнал, экологийн тайлагнал, нийгмийн хариуцлагын тайлагнал, тогтвортой хөгжлийн салбар дах тайлагнал

#### Abstract

The environment requires a change in the environment towards sustainable development. The concept of sustainable development emerged in the late twentieth century. An indispensable condition of its realization is the openness of the business. The main source of indicators and information about the social, environmental and economic aspects of companies that are available to all interested users, and performs non-financial reporting. The article provides statistics of non-financial reports of Russian companies. Discusses the regulatory framework, determining the conditions for preparing non-financial reports. The content of the policy documents of the Russian government, which include increasing social and environmental responsibility of business.

*Keywords:* sustainable development, GRI, reporting, non-financial reporting, environmental reporting, social reporting, reporting on sustainable development

---

<sup>1</sup> Доктор (Sc), профессор, ОХУ-ын Байгалийн чанад дах Улсын их сургуулийн Эдийн засаг, удирдлагын сургуулийн дэд захирал  
E-mail: soelmi@yandex.ru

Хүн төрөлхтөн экологийн болон нийгмийн хариуцлагын асар том асуудалтайгаар XXI зуунтай золгосон. XX зуунд хүмүүс байгаль дэлхийгээ хэрхэн сүйтгэснийг тоо баримт нотлон харуулж байна. Манай дэлхийгээс жил бүр халуун орны 11 сая га ой мод устан алга болж байгаа бол автомашин бүр энэ хугацаанд хэдий хэмжээний хорт хий ялгаруулна тэр хэмжээгээр нүүрсхүчлийн хий нэмэгдсээр байна. Манай дэлхийн далай тэнгисийн хүчиллэгийн хэмжээ 2000 оноос хойш 10 дахин нэмэгдсэн, нэг хүнд ногдох цэвэр усны хэмжээ дэлхий нийтийн хэмжээгээр авч үзвэл сүүлийн 40 жилд 60 хувиар буурсан байна. Хөдөө аж ахуйн зориулалттай газрын хэмжээ жил бүр 6-7 сая га-гаар багасан, тухайн зориулалтаар ашиглах боломжтой газрын хэмжээ шавхагдаж, хөрсний бохирдлын улмаас цаана нь үржил шим муутай газар үлдэж байна.

Сүүлийн 100 жилд жимс, хүнсний ногооны төрөл бүрийн витамин болон бичил элементүүдийн хэмжээ 70 хувиар багассан байна. Агаарын бохирдлын улмаас ус, бордоо нь ургамал, амьтныг мөхөлд хүргэж байна. Нэрсийн жагсаалтад бичигдсэн ургамал, амьтны төрөл зүйл дэлхий нийтийн хэмжээнд сүүлийн 50 жилд 33 хувиар багассан байна. Гэтэл дэлхийн хүн ам өдөрт 250.0 мянга буюу жилд 90.0 сая хүнээр нэмэгдсээр байна<sup>2</sup>. Үүнтэй холбоотойгоор бидний хойч үе хэрхэн аж төрөх вэ гэдэг асуудал гарах нь зүйн хэрэг.

Хүрээлэн буй орчны аажим аажмаар

өссөөр байгаа ноцтой асуудлуудын талаар хүн төрөлхтөн анзааралгүй ирсэн гэж хэлж болохгүй.

Оросын академич В. И. Вернадский (1863-1945) хүний оюун ухаан байгалийг өөрчлөгч үндсэн хүчин зүйл болж хувирсан, тийм учраас хүмүүс байгаль дэлхийнхээ ирээдүйн хөгжлийн төлөө хариуцлага хүлээх ёстой гэсэн дүгнэлтэд одоогоос 100 гаруй жилийн өмнө хүрсэн юм [1].

Английн философич Джон Ивлин (1620-1706)<sup>3</sup> бүр XVII зуунд Англид ой мод устан үгүй болж байгаа, түүнийг нөхөн сэргээх нь чухал болох талаар бичиж байлаа. Ойн аж ахуй олон жил эрхэлсэн Германийн Ганс Карл фон Карловиц (1645-1714)<sup>4</sup> нөхөн ургаж байгаа ой модноос илүү хэмжээний мод хэзээ ч тайрч болохгүй гэж хэлсэн байдаг. Английн нийгмийн нэрт зүтгэлтэн Эдвин Чедвик (1800-1890)<sup>5</sup> XIX зуунд өвчин үүсэхээс сэргийлж, хотын гудамжинд суваг байгуулах, гудамжийг угааж байх, хог хаягдлыг дахин боловсруулах санал гаргаж байжээ.

Мөн Германийн гүн ухаантан Эрнст Геккель (1834-1919)<sup>6</sup> ертөнцийн бүх зүйл хоорондоо нарийн уялдаатай бөгөөд хэрэв хүн байгальдаа ээлгүй хандвал эргээд байгаль дэлхийгээсээ хүнд цохилт амсах болно гэсэн үзэл санааг дэвшүүлж байлаа. Америкийн эрдэмтэн, ой хамгаалагч Гиффорд Пинчот (1865-1946)<sup>7</sup> болон Альдо Леопольд (1887-1948)<sup>8</sup> нар байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд цаг хугацаа, тодорхой нөхцөл зайлшгүй, уг

<sup>2</sup> <http://www.vitamarg.com/eco/article/857>

<sup>3</sup> <https://ru.wikipedia.org>

<sup>4</sup> Мөн тэнд

<sup>5</sup> Мөн тэнд

<sup>6</sup> Мөн тэнд

<sup>7</sup> Мөн тэнд

<sup>8</sup> Мөн тэнд

ажлыг хэрэгжүүлэхэд үүнийг харгалзан үзвэл зохих ба ойн аж ахуй үүний тодорхой жишээг харуулж байна гэж бичиж байжээ.

Байгалийн нөөц хязгаартай талаарх өнгөрсөн зуунуудын томъёоллыг 1972 онд тодорхой тооцоогоор батлан харуулсан. Америкийн судлаач Деннис Медоуз (1942-)<sup>9</sup> өөрийн хамтрагч нартай дэлхийн хүн амын тоо, байгалийн нөөцийн хэмжээ, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, аж үйлдвэржилт, хүрээлэн буй орчны бохирдол гэсэн бие биендээ харилцан шүтэлцээ бүхий таван хүчин зүйлд үндэслэн компьютерийн загварын тусламжтайгаар судалгаа хийсэн. Загварчилсан судалгааны үр дүнгээ Римийн “Өсөлтийн хязгаар” нэртэй клубын хурал дээр илтгэж, байгалийн нөөцийг бодлогогүйгээр ашиглах, хог хаягдлыг их хэмжээгээр гаргах нь хүн төрөлхтний тоо цаашид эцэс төгсгөлгүй өсөх боломжгүй гэдгийг нотлон харуулсан.

XX зууны сүүлчээс хүрээлэн буй орчныг хамгаалах асуудал яригдах болж, түүнийг шийдвэрлэх арга замыг эрчимтэй хайж эхэлсэн. Стокгольмын 1972 оны зургадугаар сарын 16-ны Тунхаг бичигт өнөөгийн болон хойч үеийнхээ хүрээлэн байгаа орчныг хамгаалах, ямагт сайжруулах нь манай дэлхийн чухал асуудал, шинээр бий болж байгаа үүрэг бөгөөд энэ нь дэлхий нийтийн эдийн засаг, нийгмийн хөгжилтэй уялдаатайгаар бүх хүн төрөлхтөн хамтдаа хүрэх зорилго байх ёстой гэж тэмдэглэсэн. Мөн Тунхаг бичигт хүний хүрээлэн байгаа орчны чанарыг хадгалах, сайжруулах нь дэлхийн бүх улс орны эдийн засгийн хөгжил, ард түмний

сайн сайхан байдалд нөлөөлөх чухал асуудал болж байна. Энэ үйл хэрэг нь дэлхийн бүх хүн ардын сэтгэл зориг, улс орнуудын засгийн газрын үүрэг мөн гэж заасан [2].

Стокгольмын тунхаглалын үзэл санаа «sustainable development» гэсэн нэр томъёоны дор хөгжих болсон.

НҮБ болон “Онгон байгалийн бүх дэлхийн сан”, түүнчлэн НҮБ, ЮНЕСКО-гийн Үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн байгууллагын харилцан хамтын ажиллагаа, санхүүгийн дэмжлэгтэйгээр “Байгаль хамгаалах ОУ-ын холбоо”-ноос боловсруулан 1980 оны 3-р сард гаргасан “Байгаль хамгаалах дэлхий нийтийн стратеги” нэртэй баримт бичигт анх удаа «sustainable development» гэсэн нэр томъёог хэрэглэсэн<sup>10</sup> [3].

Хүрээлэн буй орчин ба хөгжлийн олон улсын комисс буюу Норвег улсын анхны эмэгтэй ерөнхий сайд, энэ комиссын дарга Гро Харл Брундтландын нэрээр нэрлэгдсэн Брундтландын комисс “тогтвортой хөгжил”-ийн тухай ойлголтын дэлхий нийтийн хөгжил дэвшилд бодитой нөлөө үзүүлсэн. Дээрх комисс 1984 онд байгуулагдан 1987 он хүртэл үйл ажиллагаа явуулсан бөгөөд ном хэлбэрээр гаргасан “Манай ерөнхий ирээдүй” нэртэй илтгэл тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсийг тавьсан юм [4].

Хүрээлэн буй орчин ба хөгжлийн олон улсын комиссын “Манай ерөнхий ирээдүй” нэртэй илтгэлд тодорхойлсноор тогтвортой хөгжлийн ойлголт нь бидний хойч үе амьдралын хэрэгцээгээ хангах, тэгэхдээ байгалийн нөөцийн хомсдол, хүрээлэн

<sup>9</sup> <https://ru.wikipedia.org>

<sup>10</sup> “Байгаль орчноо хамгаалах бүх дэлхийн стратеги” баримт бичигт засвар оруулж 1991 оны 10-р сард “Газар дэлхийдээ санаа тавих нь тогтвортой амьдралын стратеги мөн” нэртэй гаргасан баримт бичиг

буй орчны доройтлын аюулгүйгээр тэд өөрсдийнхөө хэрэгцээг бүрэн дүүрэн хангах хөгжлийн тийм агуулгыг илэрхийлж байна гэсэн үг [4, с. 50-51].

Тогтвортой хөгжил нь онолын тодорхой загвар байхгүй гэдгийг тэмдэглэх нь чухал. Тогтвортой хөгжлийн өнөөгийн үзэл баримтлал нь өөртөө эдийн засаг, экологи, нийгмийн болон философийн үзэл санаануудыг нэгтгэж байгаа бөгөөд тэдгээр нь тогтвортой хөгжлийн агуулгын илэрхийлэл болж байна. Эндээс тогтвортой хөгжлийн ойлголтын мөн чанарыг бүрэн таньж мэдэхийн чухал нь харагдаж байна.

1992 онд Рио-де-Жанейрод Хүрээлэн буй орчин ба хөгжлийн асуудлаар болсон НҮБ-ын чуулганаас гаргасан “XXI зууны хэлэлцэх асуудал” баримт бичгийн хүрээнд Хүрээлэн буй орчин ба хөгжлийн тунхаглалыг баталсан [5]. Чуулганд оролцогч дэлхийн 179 орон экологийн тогтолцоо алдагдаж хүний амьдрах, хөгжих нөхцөл улам хүндэрч байгаатай санал нэг байгаагаа илэрхийлсэн.

Чуулганаас экологийн сөрөг нөхцөл байдлын талаар тэмдэглээд хүмүүс эрүүл, тохь тухтай байж, бүтээлчээр хөгжих, хүрээлэн буй байгаль дэлхий, түүний био орчныг хэвээр нь хадгалахын тулд амьдралаа хэрхэн зөв зохион байгуулах талаар эргэцүүлэхийг нийт хүн төрөлхтөнд уриалсан юм.

Ерөнхий Ассамблей 2015 онд дэлхийн өөрчлөлтийг сайн тийш хандуулах зорилгоор тогтвортой хөгжлийн салбарт 2030 он хүртэл мөрдөх 17 үндсэн зорилго, 169 зорилт бүхий хөтөлбөр баталж 2016 оны 1-р сарын 1-нээс эхлэн мөрдөхөөр болсон. Энэхүү хөтөлбөр нь XX зууны сүүлчээр үндэс суурь нь тавигдсан

тогтвортой хөгжлийн асуудлын үргэлжлэл болсон. Хөтөлбөр бүх улс орнуудыг хамарч байгаа бөгөөд улс орнуудын засгийн газар, бизнес эрхлэгчид болон хүн бүрийн хамтын хүчин чармайлтын үр дүнд хэрэгжих нь мэдээж [6].

Оросын тогтвортой хөгжлийн зорилт, түүний хэрэгжилтийн талаар ОХУ-ын Засгийн Газрын дэргэдэх Судалгааны төвөөс гаргасан “НҮБ болон ОХУ-ын тогтвортой хөгжлийн зорилго” илтгэлд тодорхой тусгасан [7].

Ерөнхийлөгчийн зарлигаар 2017 оныг ОХУ даяар экологийн жил болгосон [8]. “Ногоон эдийн засаг”-ийн асуудал чухлаар тавигдаж байгаа энэ үед экологийн хариуцлагаас гадуур бизнесийн болон бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй.

Экологийн болон нийгмийн хариуцлагын талаарх хэм хэмжээг мөрдөж ажиллах нь зах зээлд хандах чухал нөхцөл мөн.

Санхүүгийн бус үзүүлэлтүүдийн эрэлт бий болохын хэрээр санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаа илүү идэвхижиж байна. Арилжаанд оролцогч компаниудад экологийн болон нийгмийн хариуцлагын талаарх мэдээллээ ил тод болгохыг шаарддаг хөрөнгийн биржийн тоо өссөөр байна. 2017 оны эхэнд хөрөнгийн 58 бирж өөрийн үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зарчмыг хэрэгжүүлж ажиллах тухайгаа зарласан.

Дэлхийн улс орнуудын засгийн газрын зүгээс үндэсний зах зээлд оролцогчдод экологийн болон эдийн засаг, нийгмийн хариуцлагын тэнцвэрт байдлыг хадгалах, нийгмийн ашиг сонирхлын үндсэн дээр экологийн аюулгүй байдлыг хангаж ажиллахад тавих шаардлага нэмэгдсээр байна.

Аж ахуйг эрхлэх амаргүй байдал нь бизнесээс гадна тогтвортой хөгжлийн бүрэлдэхүүн хэсэг болох эдийн засаг, экологи, нийгмийн хариуцлагын асуудлыг үйл ажиллагаандаа баримжаа болгосоныг батлан харуулсан тайлангийн мэдээллийг бий болгох эрэлтийг төрүүлж байна.

Манай оронд тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг агуулсан тайлагналын нэр томъёо нэгэн мөр болж чадаагүй байгааг тэмдэглэх нь зүйтэй. Түүнийг тогтвортой хөгжлийн салбар дахь санхүүгийн бус тайлагнал, экологийн болон нийгмийн хариуцлагын тайлагнал, нэгтгэсэн тайлагнал, нийгмийн хариуцлагын тусгай тайлагнал гэх мэтээр нэрлэж байна.

ОХУ-ын компаниуд санхүүгийн бус тайлагналыг бэлтгэхдээ үндэсний болон олон улсын хэд хэдэн төрлийн баримт бичиг удирдлага болгож байна. НҮБ-ын Ерөнхий гэрээний<sup>11</sup> агуулгын хүрээнд ОХУ-ын үйлдвэр, бизнес эрхлэгчдийн холбоо (ОХУҮБЭХ)-ны санаачлагаар ОХУ-ын бизнесийн үйл ажиллагааны нийгмийн хариуцлагын эрх зүйн баримт бичгийг боловсруулж гаргасан<sup>12</sup>.

Энэ баримт бичиг компаниудын зүгээс сонирхогч талууд болох хөрөнгө оруулагчид, засаг захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран тогтвортой хөгжлийн хүрээнд өөрийн салбарын бодлогоо боловсруулахад компаниудын хоорондын харилцан уялдааг хангах үндэс болж байна<sup>13</sup>. ОХУ-д Олон улсын стандарт

ISO 26000-гийн хүрээнд ГОСТ ИСО 26000 “Нийгмийн хариуцлагын гарын авлага”<sup>14</sup> гэсэн үндэсний стандартыг мөрдөж байна.

Сонирхогч талуудад зориулсан тайланг бэлтгэхэд компанийн үйл ажиллагааны талаарх тэдний саналыг бүрэн тусгах замаар санхүүгийн бус тайлагналын чанар, үнэн зөв байдлыг хангах зорилгоор Британийн Институтээс боловсруулан гаргасан нийгмийн хариуцлагын болон ёс зүйн тайлагналын АА 1000 бүлэг стандартыг компаниуд хүсвэл ашиглаж болно.

Хүний эрхийг сахин хамгаалах, ажиллагчдын хөдөлмөрийн нөхцлийг сайжруулахыг эрмэлзэж байгаа компаниудын хувьд Компанийн нийгмийн хариуцлагын стандарт 8000-ыг ашиглана.

Арга зүйн хувьд авч үзвэл санхүүгийн бус тайлагналыг бэлтгэхэд ОХУ болон олон улсын практикт одоогоор нийтлэг мөрдөж байгаа баримт бичиг бол Тайлагналын ерөнхий санаачлагын гарын авлага (Global Reporting Initiative (GRI))<sup>15</sup> юм.

ОХУҮБЭХ өөрийн хөтөлбөрийн дагуу Санхүүгийн бус тайлагналын үндэсний бүртгэл бий болгосон. Өнөөдөр энэ бүртгэлд хамгийн багадаа нэг удаа тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг нээлттэй байдлаар харуулсан 162 компани, салбарын 4 холбоо бүртгэгдсэн байна<sup>16</sup>. Энэ тоо санхүүгийн бус тайлан гаргадаг компаниудын тоог үнэн зөв харуулж чадахгүй байгааг анхаарах хэрэгтэй. Үүнд зарим компаниудын өөрсдийн сайт дээрээ

<sup>11</sup> <http://www.globalcompact.ru>

<sup>12</sup> <http://pcnp.pf>

<sup>13</sup> 2008 оны 2-р сард ОХУ-ын үйлдвэр, бизнес эрхлэгчдийн холбооны их хурлаар батлагдсан баримт бичиг, одоо өөрчлөлт хийж байгаа

<sup>14</sup> <http://pcnp.pf>

<sup>15</sup> <https://www.globalreporting.org>

<sup>16</sup> <http://pcnp.pf/simplepage/157>

тавьсан тоо ч орсон юм.


Санхүүгийн бус тайлагналын үндэсний бүртгэлийн гол байгууллага болох ОХУҮБЭХ санхүүгийн бус тайлангаа Үндэсний бүртгэлийн санд байршуулахыг компаниудад уриалж байна. ОХУҮБЭХ 2012 онд Тайлагналын ерөнхий санаачлагын байгууллага (GRI)-тай хэлэлцээр хийсэн учир олон улсын энэ байгууллага (GRI)-ын мэдээллийн санд компанийн зөвшөөрснөөр санхүүгийн бус тайлангаа байршуулах боломжтой болсон. Энэ нь сонирхсон хэрэглэгчдэд мэдээллийг богино хугацаанд олж авч түүнд дүн шинжилгээ хийх, нийтлэгдсэн үзүүлэлтүүдийг үндэсний төдийгүй бусад улс орнуудын ижил төрлийн үзүүлэлтүүдтэй харьцуулах боломжийг олгодог.

“Рязанская ГРЭС” (Рязанын дүүргийн цахилгаан станц) нээлттэй хувьцаат

компанийн 2000 оны санхүүгийн бус анхны тайланг 2001 онд Аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн бус тайлагналын бүртгэлийн санд байршуулсан. 2017 оны 11-р сарын 1-ний байдлаар дээрх санд 781 тайлангийн мэдээллийг бүртгэж байршуулаад байна<sup>17</sup>. Компаниудын бүртгэгдсэн тайлангийн тоо зөрүүтэй байгаа бөгөөд энэ нь манай улсын компаниудын гаргаж байгаа санхүүгийн бус тайлангийн тоо нэгээр хязгаарлагддаггүйтэй холбоотой. Тухайлбал тайлангийн нэг үед экологийн болон нийгмийн хариуцлагын, мөн нийгмийн хариуцлагын нэгтгэсэн (холимог) зэрэг тайлангууд гаргадаг. Мөн зарим компани санхүүгийн бус тайланг жил бүр биш хоёр, гурван жилийг тайлангийн үе болгон сонгож тайлангаа гаргах нь бий.

Санхүүгийн бус тайлан гаргадаг ОХУ-ын компаниудын тоог жилээр харуулбал:

Зураг 1. Санхүүгийн бус тайлан гаргадаг ОХУ-ын компаниудын тоо



Санд бүртгэгдсэн 781 тайлангийн 70 нь экологийн, 325 нь нийгмийн хариуцлагын, 258 нь тогтвортой хөгжлийн, 128 нь холимог тайлан байна.

Хүснэгтээс үзэхэд Үндэсний бүртгэлийн санд тайлангаа бүртгүүлсэн оросын компаниудын дотор хамгийн их хувийг эрчим хүчний салбарын компаниуд эзэлж

<sup>17</sup> <http://pcnp.pф/simplepage/157>

Хүснэгт 1. Тайлагналыг компаниудын салбарын харъяалал,  
санхүүгийн бус тайлагналын төрлөөр  
(2017 оны 11-р сарын 1-ний байдлаар)

Компанийн салбарын харъяалал	Компанийн тоо	Тайлангийн тоо				
		Тогтвортой хөгжлийн тайлан	Нийгмийн хариуцлагын тайлан	Экологийн тайлан	Хосолсон тайлан	Дүн
Эрчим хүчний	41	52	44	5	72	173
Нефть хийн	19	93	9	36	2	140
Санхүү даатгал	18	17	63	0	3	83
Металлург болон уулын баяжуулах	18	32	50	2	7	91
Хими, нефтьхими, үнэртэн	12	14	20	2	31	67
Харилцаа холбоо	11	8	20	0	4	32
Хүнс	9	20	22	0	0	42
Мод боловсруулах болон целлюло-цаас	5	1	4	18	0	23
Орон сууц	5	0	13	1	1	15
Боловсрол, эрүүлийг хамгаалах	5	0	12	0	0	12
Тээвэр	5	5	10	5	0	20
Бусад үйлчилгээ	5	9	7	0	0	16
Ашгийн бус байгууллага	5	5	27	0	0	32
Машин, тоног төхөөрөмжийн үйлдвэр	2	0	0	0	8	8
Цемент болон барилгын үйлдвэрлэл	2	1	0	1	0	2
ДҮН	162	257	300	70	128	755
Салбаруудын холбоо	4	1	25	0	0	26
БҮГД	166	258	325	70	128	781

Эх үүсвэр: [rsp.ru/simplepage/157](http://rsp.ru/simplepage/157)

байна. Гэвч компанийн тоотой харьцуулж үзэхэд нийтлэгдсэн тайлангийн тоогоороо нефть хийн салбарын компаниуд тэргүүлж байна. Энэ салбарын компаниудын экологи, эдийн засаг, тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг харуулсан тайлан олон тоотой байна. Бүхэлдээ Үндэсний бүртгэлийн сангийн санхүүгийн бус тайлагналын мэдээлэл дотор нийгмийн хариуцлагын тайлан хамгийн олон байна. Энэ нь манай улсад санхүүгийн бус тайлан бэлтгэх гол удирдамж нь нийгмийн хариуцлагын холбогдох баримт мэдээлэлд илүүтэй чиглэгдсэн байдагтай холбоотой.

2015 онд бүртгэлийн санд ирүүлсэн тайлангийн 72% нь G4 (гар утасны шинэ

сүлжээ)-ийн шаардлагыг хангасан байна.

Мэдээллийн ил тод байдал нь эрсдэлийг таньж мэдэх, удирдлагын системээ сайжруулах боломжийг олгодог. Ажлын үр дүнг сайжруулах нь сонирхогч талуудын итгэлийг нэмэгдүүлдэг. Гэвч оросын компаниудын санхүүгийн бус тайлагналын ил тод байдлын тухай асуудал нь төвөгтэй хэвээр байна.

Санхүүгийн бус тайлагналын үзэл баримтлалын үүднээс авч үзвэл тайланд байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд холбоотой зөвхөн эерэг төдийгүй сөрөг асуудлуудыг ч авч үзэх ёстой.

Одоогийн байдлаар дотоодын компаниуд



үйл ажиллагааныхаа зарим сөрөг талыг тайланд бүрэн тусгах эрмэлзэлгүй байгаа, компанийн нэр хүнд буурч болзошгүй гэж үзсэн зэргээс зөвхөн богино хугацааны зорилтыг тусгасан санхүүгийн бус тайлан гаргахыг чухалчилж байна. Ил тод байдал цаашид байнга хадгалагдах нь тайлагналын давуу тал болдгийг ойлгох хэрэгтэй.

Улс орондоо бизнесийн нийгэм-экологийн хариуцлага, нэвт тунгалаг байдлыг дээшлүүлэх гэсэн Оросын засгийн газрын сонирхол нь улсын хэмжээнд гаргаж байгаа баримт бичгүүдэд тусгалаа олж байна. Үүний нэг жишээ бол ОХУ-ын ерөнхий сайд В. В. Путины 2012 оны 3-р сарын 30-ны 1710п-П13 дугаартай захирамж юм. Энэ захирамжаар төрийн өмчит 22 том компанийн нэрсийн жагсаалтыг баталж, санхүүгийн бус тайлангаа тогтмол нийтэлж байхыг үүрэг болгосон. Мөн ОХУ-ын Засгийн газрын 2017 оны 5-р сарын 5-ны өдрийн 876 тоот тогтоолоор Нээлттэй санхүүгийн бус тайлагналыг хөгжүүлэх үзэл баримтлал, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан.

Энэхүү үзэл баримтлалд дотоодын компаниудын мэдээллийн ил тод болон үйл ажиллагааны үр дүнгийн нэвт тунгалаг байдал, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл; нийгмийн хөгжилд оруулсан бодитой хувь нэмэр; дотоодын компаниудын нэр хүнд, тэдний үйл ажиллагаанд итгэх итгэл; удирдлагын үйл ажиллагаанд санхүүгийн бус мэдээллийг ашиглаж байгаа байдал; тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх болон нээлттэй санхүүгийн бус тайлагналын ач холбогдлыг өөрийн компани, харилцагчиддаа хэрхэн ойлгуулж байгаа зэргийг харгалзсан урамшууллын системийг боловсронгуй

болгох асуудлыг тусгасан.

Үзэл баримтлалд тусгагдсан арга хэмжээнүүдийг дөрвөн үе шаттайгаар хэрэгжүүлэх юм. Үүнд:

*Нээдүгээр шат (2017-2018 он).* Энэ үе шатанд санхүүгийн бус тайланг бэлтгэх, нийтлэх заавар журам, арга зүй, компанийн үйл ажиллагааг хараат бус байдлаар үнэлж дүгнэх тогтолцоог бий болгох, нээлттэй санхүүгийн бус тайлагналын салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэх, тэднийг мэргэшүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэх, үндсэн үзүүлэлтүүдээ нээлттэй болгож, санхүүгийн бус тайлан гаргаж нийтлүүлэх шаардлагатай компаниудын тоог нэмж тогтоох ажлууд хийгдэнэ.

*Хоёрдугаар шат (2019-2020 он).* Эхний шатны ажлуудыг үргэлжлүүлэхийн зэрэгцээ санхүүгийн бус тайланд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын индекс, чансаа (рейтинг) тогтооно.

Санхүүгийн бус тайлан гаргаж нийтлүүлэхээр заасан төрийн үйлчилгээний компани, төрийн өмчит болон нээлттэй хувьцаат компани; төрийн эзэмшдэг хувьцааны буюу дүрмийн сангийн 50-иас багагүй хувь бүхий бизнесийн байгууллага; тайлант онд борлуулалтын орлого болон хөрөнгийн хэмжээ нь 10 тэрбум рубль, ажиллагчдын дундаж тоо нь 4,000 ба түүнээс дээш төрийн өмчит үйлдвэрийн газар; төрийн өмчийн хувьцаа дүрмийн сангийнх нь 50-иас багагүй хувь эзэлдэг, түүнчлэн үнэт цаасаа зохион байгуулалттай зах зээлд гаргадаг бусад бизнесийн байгууллагыг нэмж оруулах замаар санхүүгийн бус тайлан гаргаж нийтлүүлэхээр заасан компаниудын тоог нэмэгдүүлнэ. Эдгээр байгууллагууд 2019 оноос эхлэн өмнөх



санхүүгийн бус тайлангуудаа нийтлэхээр болсон.

*Гуравдугаар шат (2021-2022 он).*

Санхүүгийн бус тайлан гаргадаг компанийн тоог нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэхийн зэрэгцээ мэдээллийн нээлттэй байдал, байгууллагын үйл ажиллагааны нэвт тунгалаг байдлыг дээшлүүлэхэд чиглэгдсэн зохион байгуулалтын болон урамшууллын системийг боловсронгуй болгох, түүнчлэн нээлттэй санхүүгийн бус тайлагналын үндсэн дээр компаниудын үйл ажиллагаанд үнэлэлт өгөх ажлын хараат бус байдлыг хангах; санхүүгийн бус тайлагналыг баталгаажуулах асуудлыг шийдвэрлэнэ. Санхүүгийн бус тайлан гаргаж нийтлүүлэхээр заасан төрийн эзэмшдэг хувьцааны буюу дүрмийн сангийн 50-иас багагүй хувь бүхий бизнесийн байгууллага, тайлант онд борлуулалтын орлого болон хөрөнгийн хэмжээ нь 5 тэрбум рубль, ажиллагчдын дундаж тоо нь 2,000 ба түүнээс дээш төрийн өмчит үйлдвэрийн газар; үнэт цаасаа зохион байгуулалттай зах зээлд гаргадаг бизнесийн байгууллагыг нэмж оруулах замаар санхүүгийн бус тайлан гаргаж нийтлүүлэхээр заасан компаниудын тоог нэмэгдүүлнэ.

*Дөрөвдүгээр шат (2023 оноос хойш).*

Санхүүгийн бус тайлан гаргаж нийтлүүлэх ажлыг зохион байгуулах, урамшуулах механизм үйлчилсэн хэвээр байна. Борлуулалтын орлого нь тэргүүлэх компаниудад чансаа (рейтинг) тогтоох гол үзүүлэлт байх бөгөөд санхүүгийн бус тайлан гаргаж нийтлүүлэх томоохон компанийн тоог 500-д хүргэх юм.

ОХУ дахь санхүүгийн бус тайлагналын асуудлаар дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн бол бизнесийн хариуцлага хүлээлгэхгүйгээр хүн төрөлхтөн цаашид оршин тогтнох боломжгүй;
- Санхүүгийн бус тайлагнал нь компани үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг баримжаа болгож байгаа байдлыг харуулах үндсэн мэдээлэл нь болсон;
- Олон улсын хөрөнгийн зах зээлд оролцогч, манай улсын гол томоохон компаниуд санхүүгийн бус тайланг харьцангуй эртнээс гаргаж эхэлсэн;
- Сүүлийн жилүүдэд манай оронд санхүүгийн бус тайлагналын эрчимтэй өсөлт нь томоохон компаниудын тоог хязгаарласнаас болж удааширсан;
- Компаниуд нийгмийн хариуцлагын болон экологийн үзүүлэлтүүдийг өөрийн үйл ажиллагаандаа хэрэглэх нь харилцан адилгүй түвшинд байгаа ч салбараар нь авч үзвэл эрчим хүч, газрын тос болон байгалийн хийн компаниуд энэ талаараа тэргүүлж байна;
- Оросын компаниудын санхүүгийн бус тайлагналын удирдамжийн үндсэн баримт бичиг нь Олон улсын стандарт ISO 26000, Тайлагналын ерөнхий санаачлагын гарын авлага (Global Reporting Initiative (GRI)) болж байна;
- Оросын компаниуд сүүлийн жилүүдэд онцлон авч үзэж байсан асуудал (нийгмийн хариуцлагын болон экологийн)-аас эдийн засаг, экологи, нийгмийн хариуцлагын гэсэн гурвалсан бүлэг асуудалд шилжиж байна;
- Сүүлийн жилүүдэд батлан гаргасан үзэл баримтлалын шинжтэй хэд хэдэн баримт бичиг нь төрийн зүгээс санхүүгийн бус тайлагналыг хөгжүүлэх сонирхлын илэрхийлэл болж байна.

Өгүүллийн [...] тэмдэглээн дэх эх үүсвэрийг оросоор хэвлэгдсэн өгүүллийн ашиглах материалаас харна уу.

Товчилсон үгийн тайлбар

1. ОХУ – Оросын Холбооны Улс
2. НҮБ – Нэгдсэн Үндэстний Байгууллага
3. ЮНЕСКО – United Nations Educational, Scientific and Cultural Organization гэсэн англи нэрийн эхний үсгийн крилл товчлол, монголоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
4. РСПП – (Российский Союз Промышленников и Предпринимателей) ОХУ-ын үйлдвэр, бизнес эрхлэгчдийн холбоо
5. ОХУҮБЭХ – ОХУ-ын Үйлдвэр, Бизнес Эрхлэгчдийн Холбоо
6. ISO – (International Organization for Standardization) Олон улсын стандартын байгууллага
7. ИСО – ISO гэсэн англи товчлолын орос тэмдэглээ
8. ГОСТ – (Государственный Стандарт) Улсын стандарт
9. АА – (Institute of Social and Ethical Accountability – “AccountAbility”) Нийгмийн хариуцлагын болон ёс зүйн тайлагналын институтээс гаргадаг бүлэг стандарт
10. GRI – (Global Reporting Initiative) Тайлагналын ерөнхий санаачлагын гарын авлага
11. ГРЭС – (Государственная Районная Электрическая Станция) Дүүргийн төрийн өмчит цахилгаан станц

Орос хэлнээс орчуулсан  
Доктор (Ph.D), дэд профессор  
Л. Мөнх-Очир